



**№1.17. ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙД МАЛ ЭМНЭЛЭГ,
АРИУН ЦЭВЭР, ХОРИО ЦЭЭРИЙН ДЭГЛЭМИЙН
МӨРДӨЛТИЙГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:/.../..

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
	1	2	3	4	5	6
Нэг. Хуулийн холбогдох заалтууд			0	110	0	0
1	Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.1.1	Малын үүлдэрлэг байдлыг батжуулан сайжруулж, ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлдэг	0	10		
2	Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.1.4	Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээнд биотехнологийн ололтыг нэвтрүүлдэг	0	10		
3	Малын генетик нөөцийн тухай хуулийн 8.4.2	Үр хөврөлийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн хяналтын доор ашигладаг	0	10		
4	Малын генетик нөөцийн тухай хуулийн 14.1.2	Эрчимжсэн мал аж ахуйн малд ашиг шимийн чиглэл, биологийн онцлогт тохирсон арчилгаа, маллагаа, тэжээллэгийн технологи мөрдөж, малыг өлдөөхгүй байх, аюулгүй нөхцөлөөр хангагдсан	0	10		

5	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.3.1	Мал, амьтан маллагч нь малын эмчийн зааварчилгааны дагуу өвөлжөө, хаваржаа болон эрчимжсэн мал аж ахуйн байрны ойр орчимд мал, амьтны хүүр, сэг зэм, биологийн хаягдал устгах зориулалтын цэг барьж ашигладаг	0	10		
6	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9.8.1	Товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж дархлаажуулалтад бүрэн хамруулдаг	0	10		
7	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15.3.1	Өвчний сэжиг илэрсэн тохиолдолд гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр эрчимжсэн аж ахуйн бүх малд эрүүл мэндийн үзлэг хийлгэж, тархвар зүйн байдлыг тодорхойлуулж, өвчний эмнэл зүйн шинж тэмдгийг тогтоолгодог	0	10		
8	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24.2	Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь жоргүй олгохоор зөвшөөрөгдсөн эм хэрэглэхдээ малын эмчээс зөвлөгөө, зааварчилгаа авдаг	0	10		
9	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24.4.3	Жороор олгох мал, амьтны эмийг жоргүйгээр дур мэдэн хэрэглээгүй	0	10		
10	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 26.3	Малын эмч, эсхүл малчин мал, амьтны эмчилгээнд хэрэглэсэн эмийн нэр, огноо, хэрэглэсэн тун, хэмжээний талаарх мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн бүртгэлийн дэвтэрт тухай бүр тэмдэглэж, баримтжуулдаг	0	10		
11	Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 26.5	Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм худалдан авдаггүй	0	10		
Хоёр. Үйлдвэрийн гадна орчин, барилга байгууламж			0	70	0	0

12	Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандартын 7.2	Аж ахуйн нэгж нь 1000-аас доош толгой малтай бол эрүүл ахуйн хамгаалалтын бүс нь 300 м-т, 1000-аас дээш толгой малтай бол 500 м-т байрладаг	0	10		
13	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.3.1	Эрчимжсэн аж ахуйн барилга, байгууламжийг мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд, мэргэжлийн байгууллагаас баталсан зураг төслийн дагуу барьсан	0	10		
14	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.3.2	Барилга байгууламж нь малын төрөлхийн зан, авираа илэрхийлэх боломжтой, малд өвдөлт, айдас, гэмтэл учруулахгүй, тайван байх нөхцөлийг бүрдүүлсэн зохион байгуулалттай	0	10		
15	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.3.3	Эрчимжсэн аж ахуйн үндсэн байгууламж нь хүчин чадлаасаа хамаарч малын нас, төрөлд тохирсон	0	10		
16	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.3.4	Эрчимжсэн аж ахуйн барилга нь нормативт заасан халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлсэн талбайтай, эрүүл ахуйн шаардлага хангасан орчныг бүрдүүлсэн	0	10		
17	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.3.5	Эрчимжсэн аж ахуйн байрыг малын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хана, тааз дулаан алдахгүй, шал нь мал хальтархаас хамгаалсан үрэлттэй, зуурамхай гадаргуутай, угааж цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн	0	10		

18	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.4	Эрчимжсэн аж ахуйн туслах байгууламжид өвс хадгалах талбай, тэжээлийн ургамал болон ногоон тэжээл тариалах талбай, тэжээл болон даршны агуулах, лаборатори, мал эмнэлэг, үржлийн хэсэгтэй	0	10		
Гурав. Хүн хүч /ажиллагсадын/ ариун цэвэр, эрүүл ахуй			0	30	0	0
19	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.6.1	Эрчимжсэн аж ахуйн үндсэн ажилтан нь аж ахуйн эзэн, малчин, саальчин байх ба туслах болон гэрээт малын эмч, мал зүйчтэй	0	5		
20	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.6.2	Малчин, саальчин нь малын арчилгаа, маллагааны арга технологийг эзэмшсэн, малтай харьцах зөв дадалд суралцсан малын тавлаг байдлыг хангах журам, зааврыг мөрдөж ажилладаг	0	5		
21	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 5.6.3	Малчин, саальчин нь малыг технологийн зааврын дагуу тэжээх, услах, саах, тоног төхөөрөмжийг шалгах, тохируулах, ажиллуулах ур чадвартай	0	5		
22	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.7, 10.1.8	Хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалт, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулдаг	0	15		
Дөрөв. Ариутгал халдваргүйжүүлэлт			0	30	0	0
23	"Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хуулийн 22.1	Малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис хэрэглэсэн	0	15		
24	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27.1.1	Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээр байр, орчинд халдваргүйтгэл хийлгэж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан	0	15		
Тав. Бүтээгдэхүүний баталгаажилт, хадгалалт тээвэрлэлт			0	80	0	0

25	"Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 8.1.2	Мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалдаг	0	10		
26	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1.3	Амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд үзүүлсэн бүртгэлтэй	0	10		
27	Сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйд тавих ерөнхий шаардлага MNS 6723:2018 стандартын 6.5.1	Сүүний эрүүл ахуйд сүүг бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, түгээх хэрэглэгчдийн гар дээр хүрэх дамжлагад хөдөө аж ахуйн зохистой дадлыг хэвшүүлж, бүртгэл хөтөлдөг	0	10		
28	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.1, "Төв суурин газарт сүү, цагаан идээ худалдаалах үеийн ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг журам" 2.6	Сүүгээ хадгалах, тээвэрлэхдээ сүүний аюулгүй байдалд нөлөөлөхгүй зориулалтын сав суулга ашигладаг.	0	15		
29	Малын түүхий сүү. Техникийн шаардлага MNS 4228:2003 стандартын 4.2	Сүү нийлүүлэх өдөр тутмын бүртгэлийн дэвтэрт халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, угаалга, туулгалтанд хамрагдсанаас хойш 7-14 хоногт хэрэгцээнд сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлээгүй болохыг бүртгэсэн бүртгэлтэй.	0	15		
30	Малын түүхий сүү. Техникийн шаардлага MNS 4228:2003 стандартын 4.4	Өдөр тутам худалдан борлуулсан сүүний бүртгэл хөтөлдөг.	0	10		
31	"Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" хуулийн 9.1	Түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтөлдөг.	0	10		
Зургаа. Хог хаягдал болон бохирдлын менежмент			0	48		

32	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2	Шаардлага хангасан хогийн савтай	0	9		
33	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулсан	0	6		
34	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.6	Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлдэг	0	6		
35	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг	0	9		
36		Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг	0	9		
37		Дотоод хяналт шалгалтын тайлан гаргадаг	0	9		
НИЙТ ОНОО			0	368	0	0
БАТАЛГААЖУУЛАЛТ						
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>		<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>			
<i>/ овог, нэр/</i>		<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>			
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>		<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>			

Тайлбар:

|